

## 2016 оны эдийн засгийн нөхцөл байдалд Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшнийг санхүүжүүлэх боломжтой юу?

**Эдийн засгийн хямралын үед бүх нийтийн нийгмийн хамгаалал шаардлагатай байна.**

Монгол Улс нийгмийн шударга ёсны, тэр дундаа нийгмийн хамгааллын эртний уламжлалтай. Өнгөрсөн хорин жилийн хугацаанд тус улс 3 сая иргэндээ зориулж нийгмийн даатгал, халамж, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогоос бүрдсэн цогц тогтолцоог бий болгож чадсан юм.

Нийгмийн хамгааллын хамралтыг өргөжүүлэх чиглэлд тус улс гайхалтай ахиц гаргаж, бүх нийтийг хамарсан нийгмийн хамгааллын хэд хэдэн хөтөлбөр (эрүүл мэндийн даатгал, боловсрол, хүүхдийн мөнгөн тэтгэмж) нэвтрүүлсний зэрэгцээ хувийн хэвшилд ажиллагчид болон төрийн албан хаагчдын нийгмийн даатгалд хамрагдалт өндөр байна (2014 онд 79.8 хувь). Гэсэн ч малчид, хувиараа хөдөлмөр эрхэгчид, албан бус хэвшилд ажиллагч 4 хүн тутмын нэг нь л нийгмийн даатгалд сайн дураар даатгуулж байгаа нь энэ бүлгийн ажиллагчдын дийлэнх олонхийг үйлдвэрлэлийн осолд өртөх, ажилгүй болох, өвчлөх, жирэмслэх, амаржих, хөдөлмөрийн чадвараа алдах болон өндөр наслах тохиолдолд хамгаалалтгүй үлдэхэд хүргэж байна. Түүнчлэн нийгмийн хамгааллын тогтолцоо нь эдийн засгийн мөчлөг, төсвийн хүндрэлийн үед эмзэг өртөмхий хэвээрээ байгаа нь нийгмийн хамгааллын хөтөлбөр, үйлчилгээний тогтвортой байдал, хүртээмж, чанарт сөргөөр нөлөөлж байна.

НҮБ-ын Монгол Улс дахь Удирдлагын багийн дэмжлэгтэйгээр Засгийн газар, түүний дотор Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн яамнаас тус улсын нийгмийн хамгааллын суурь түвшнийг тодорхойлох хэлэлцүүлгийг үндэсний бусад талуудтай хамтран 2013-2014 онд зохион байгуулсан юм. Хэлэлцүүлэгт оролцогч талууд нийгмийн хамгааллыг хүний үндсэн эрх гэдгийг хүлээн зөвшөөрч, үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон нийгмийн хамгааллын суурь түвшнийг бүрэн хэрэгжүүлэх замаар нийгмийн хамгаалалд бүх нийтийг хамруулах зарчмыг хадгалах нь зүйтэй гэж үзсэн байна. Монгол Улс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эхчүүдийн болон хүүхдийн нийгмийн хамгааллын хүрээнд бүх нийтийг хамруулсан хэд хэдэн тэтгэмж, үйлчилгээг хүргэж байна. Засгийн газар нийгмийн хамгааллын бусад төрөлд бүх нийтийг хамруулахыг зорьж байгаагийн дотор ирээдүй хойч үеэ өндөр насны тэтгэвэрт, хөдөлмөрийн насны хүмүүсийг нийгмийн даатгалд бүрэн хамрагдах боломжийг бүрдүүлэх асуудал багтаж байгаа юм.

Эдийн засгийн бууралт, ядуурал, тэгш бус байдал бодитой нүүрэлсэн энэ үед өнгөрсөн 10 жилд ядуурлыг бууруулах чиглэлд олсон ахиц дэвшлээ хэвээр хадгалахын тулд нийгмийн хамгааллыг бататгаж, өргөжүүлэх шаардлага улам чухлаар тавигдаж байна. Хүн амыг эргэж ядууралд өртөхөөс сэргийлэх, одоогийн хямралын нийгэм, эдийн засгийн үр дагаварыг багасгахын тулд нийгмийн хамгааллын суурь түвшнийг нийгмийн хамгааллын тогтолцооныхоо бүрэлдэхүүнд бий болгох замаар хүн бүрийг хамгаалах нь зайлшгүй чухал юм. Гэхдээ төсвийн алдагдал 4.3 тэрбум төгрөгт (ДНБ-ий 18 хувьд) хүрч, 2016 онд эдийн засаг дөнгөж 0.6 хувиар өссөн нөхцөлд төсвийн хямралын улмаас зарлагыг хумих хатуу бодлого явуулах, түүний дотор хүмүүс, аж ахуйн нэгжүүдэд хамгийн хэрэгцээтэй байгаа үед нь нийгмийн хамгааллын зардлыг танах аюул тулгарч байна.

Ийм нөхцөлд өнөөгийн нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийг хэвээр үргэлжлүүлж, 2013-2014 онд үндэснийхээ түвшинд тодорхойлсон нийгмийн хамгааллын суурь түвшнийг бүрэн хангах боломжийг тодорхойлох зорилгоор зардлыг шинэчлэн тооцов.

## Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний нэгдсэн багц

Монгол Улсад нийгмийн хамгааллын суурь түвшнийг бүрдүүлэхэд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд 2013-2014 онд зохион байгуулсан үндэсний хэлэлцүүлгээс дараах зөвлөмжийг гаргасан юм.

### Зураг 1. 2013-2014 онд зохион байгуулсан үндэсний хэлэлцүүлгээр тодорхойлсон Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшин

|                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <br><b>ЭРҮҮЛ МЭНД</b>                 | <p>Эмзэг бүлгийн иргэд болон малчдын төлөх шимтгэлийг төрөөс бүрэн хариуцах замаар бүх нийтийг эрүүл мэндийн даатгалд хамруулах</p> <p>Бүх хүнд чанартай, олдоцтой, боломжийн үнэ өртөг бүхий эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улс орон даяар хүргэх, хөдөө орон нутагт тусламж үйлчилгээ, нийлүүлэлтийг сайжруулах</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | <br>                                                                                                                                                                                       |
| <br><b>ХҮҮХЭД</b>                     | <p>Ерөнхий боловсролыг бүх хүүхдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэх, сургуулийн дотуур байраар үнэ төлбөргүй хангах</p> <p>Бүх хүүхэд хүүхдийн мөнгөнд хамрагдаж байгааг хуулиар баталгаажуулж, амьжиргааны өртөгийн өсөлттэй уялдуулан автоматаар индексжүүлж байх</p> <p>Цэцэрлэгт хамрагдаж буй (2-5 насны) бүх хүүхдийн хоолны зардлыг амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулж индексжүүлэн нэмэгдүүлэх замаар бага насны хүүхдийн хоол тэнгээлийн чанарыг сайжруулах</p> <p>Малчин өрхийн хүүхдийн үндсэн эрх, хөгжлийг хангахуйцаар орчин нөхцөлийг сайжруулах</p>                                                                                                                                                                                                                                                           | <br><br><br>        |
| <br><b>ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ</b> | <p>Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын төлөх шимтгэлд (улсын төсвөөс 50 хувийн) татаас өгөх замаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд бүрэн хамруулах</p> <p>Хөдөлмөр эрхэлж буй бүх хүнд, түүний дотор малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдад жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг өмнөх орлогыг нь 100 хувь нөхөх хэмжээнд олгох</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг бэхжүүлж, залуу малчдад зориулсан тусгай хөтөлбөрийг нэвтрүүлэх</p> <p>Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хохирсон иргэд болон ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авч буй иргэдийг ажил хөдөлмөр эрхлэх, давтан сургах хөтөлбөрүүдэд хамруулах</p> | <br><br><br> |
| <br><b>АХМАД НАСТАН</b>             | <p>Тэтгэврийн гурван давхаргат тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:</p> <ul style="list-style-type: none"><li>- Бүх нийтийг хамарсан суурь тэтгэвэр: тэтгэврийн хэмжээг амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан индексжүүлж байх</li><li>- Өндөр насны тэтгэврийн албан журмын даатгал: Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын төлөх шимтгэлд (улсын төсвөөс 50 хувийн) татаас олгох замаар заавал даатгуулдаг болох</li><li>- Тэтгэврийн нэмэлт хөтөлбөрүүд</li></ul> <p>Ядуу амьдралтай ахмад настуудад мөнгөн ба түүнтэй адилтгах тусламж үзүүлж буй одоогийн нийгмийн халамжийн хөтөлбөрүүд дээр үндэслэн ахмадууд зориулсан тусламж, үйлчилгээний нэгдсэн багц бий болгох. Үүнд урт хугацааны асрамжийн тогтолцоог хамруулах.</p>                                                    | <br><br>                                                                                          |

 Одоо байгаа, сайжруулах шаардлагатай.  Шинээр бий болгох.


Эх сурвалж: НҮБ, Монгол Улсын Засгийн газар, 2015: Үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлэг: Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний тодорхойлолт, зардал (ОУХБ, Улаанбаатар)

### 2016 оны эдийн засгийн нөхцөлд үндэслэн тооцоход Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний зардал ямар байх вэ?

Энэ удаагийн тооцооллоор 2014 онд талуудын тодорхойлсон нийгмийн хамгааллын суурь түвшний зардлын тооцоог шинэчлэх, мөн Монгол Улс одоогийн нийгмийн хамгааллын арга хэмжээнүүдээ

үргэлжлүүлэн санхүүжүүлэх, улмаар нийгмийн хамгааллын суурь түвшнийг хангах санхүүгийн боломжтой эсэхэд хариулт өгөх зорилго тавьлаа. Үндэснийхээ түвшинд тодорхойлсон нийгмийн хамгааллын суурь түвшнийг хангахад 2020 онд шаардагдах нэмэлт зардал 2014 онд хийсэн өмнөх тооцооллын дүнгээс бага гарсан нь урьдчилан таамагласнаас зөрж байна.

**Зураг 1. Нийгмийн хамгааллын суурь түвшнийг хангахад шаардагдах нэмэлт зардал, хөтөлбөр түс бүрээр, ДНБ-нд эзлэх хувиар (2016–2020) (2016 оны төсөөллийг ашиглан тооцсон)**



Эх сурвалж: ОУХБ-ын тооцоо, 2016

Үндэснийхээ түвшинд тодорхойлсон нийгмийн хамгааллын суурь түвшнийг хангахад одоогийн нийгмийн хамгааллын зардал (төсөөлөл) дээр нэмж ДНБ-ий 1.19 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилт шаардагдахаар байна. Харин 2014 оны тооцоогоор энэхүү нэмэлт зардлын хэмжээ ДНБ-ий 1.68 хувьд хүрэхээр байсан юм.

Эрүүл мэндийн даатгал бараг бүх нийтийг хамарсан тул дээрх нэмэлт хөрөнгийг хүүхдийн нийгмийн хамгаалал, хоол тэжээлийн байдлыг сайжруулах, хөдөлмөрийн насны хүн амын орлогын баталгаа, хөдөлмөр эрхлэх чадварыг дээшлүүлэх, түүнчлэн ахмад настны нийгмийн хамгаалалд голчлон зарцуулна.


Хоёр удаагийн тооцооллоор гарсан зардлын дүн ялгаатай байгаа нь хүүхдийн мөнгө, нийгмийн даатгалын тэтгэмжүүд, хөдөлмөрийн насны хүн амд зориулсан хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүд, өндөр насны тэтгэврийн зардлын зөрүүгээс үүдсэн байна. 2020 онд нийгмийн хамгааллын суурь түвшнийг хангахын тулд хүүхдийн баталгаанд ДНБ-ий 0.33 хувь, хөдөлмөрийн насны хүн амын баталгаанд 0.47 хувь, өндөр настны баталгаанд 0.38 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилт шаардагдана. Харин 2014 оны тооцоогоор эдгээр нэмэлт зардал нь ДНБ-ий 0.6, 0.6, 0.48 хувьтай түс түс тэнцэхээр байсан юм.

Энэ удаагийн тооцоонд ашигласан 2017-2020 оны инфляцийн түвшний төсөөлөл 2014 оны таамаглалаас доогуур байсан учраас ХМХ-ийн зардал өмнөх хувилбарынхаас буурсан байна.

Түүнчлэн оны үнээр тооцсон ДНБ-ий төсөөлөл 2020 онд өмнөх тооцооны дүнгээс 12 хувиар буурахаар байгаа боловч тус хөтөлбөрт нэмж шаардагдах зардал абсолют дүнгээрээ 10 нэгжээр буурч байгаа нь зардлыг нийтдээ ДНБ-ий 15 хувьтай тэнцэх хэмжээгээр бууруулж байна. Инфляцийн түвшний төсөөлөл доогуур байгаа нь хүүхдийн мөнгийг автоматаар индексжүүлэн нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж байгаа тул сарын тэтгэмжийн хэмжээ 2014 онд тооцсон дүнгээс буурч байна.

Хөдөлмөрийн насны хүн амын нийгмийн хамгаалал, өндөр насны тэтгэврийн хувьд 2014, 2016 оны зардлын тооцооллын дүн зөрүүтэй гарсан нь албан бус эдийн засгаас албан секторт шилжилт явагдахаар байгаатай холбоотой юм. Үүнийг эрүүл мэндийн албан журмын даатгалд даатгуулсан албан секторт ажиллагчдын тоо 8 хувиар өсч, сайн дурын даатгалд хамрагдсан малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо (13 хувиар) буурч байгаагаар тайлбарлаж болно.<sup>1</sup> Мөн энэ удаагийн тооцоонд ашигласан сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний таамаглал нь өмнөх тооцооныхоос доогуур байгаа тул түүнд үндэслэж тооцсон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ буурч улмаар нийт зардлын дүнд нөлөөлсөн байна.

**Зураг 2. Нийгмийн хамгааллын суурь түвшнийг хангахад шаардагдах нэмэлт зардал, баталгаа тус бүрээр, ДНБ-нд эзлэх хувиар (2016 оны төсөөллийг ашиглан тооцсон)**



Эх сурвалж: ОУХБ-ын тооцоо, 2016

2016 оны төсөөлөлд үндэслэн Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшний зардлыг тооцоход **2016 онд** нийгмийн хамгааллын зардал **ДНБ-ий 5.96 хувьд** хүрэхээр байна (Зураг 3). Харин 2020 онд нийгмийн хамгааллын нийт зардал **ДНБ-ий 5.76 хувьд** хүрэхээр төсөөлөгдөж байна. Ингэснээр одоогийн нийгмийн хамгааллын зардал дээр ДНБ-ий 1.19 хувьтай тэнцэх нэмэлт зардал шаардагдах юм.

<sup>1</sup> Нийгмийн даатгалын бусад тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг тооцохдоо (2020 онд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус хэвшилд ажиллагчид нийгмийн даатгалд бүрэн хамрагдана гэж үзэж) эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын тоог прокси болгон ашигласан юм.

Одоо тус улсад нийгмийн хамгааллын зардлыг<sup>2</sup> тооцож байгаачлан шинээр санал болгож байгаа ХЭДХ-үүдийг төсвийн өөр зүйлд хамааруулна гэж үзвэл дээр дурдсан зардлын нийт хэмжээ ДНБ-ий **5.44 хувьд** хүрч буурна. Ийм тохиолдолд 2020 онд нийгмийн хамгааллын суурь түвшнийг хангахад одоогийн нийгмийн хамгааллын зардал дээр нэмэгдээд ДНБ-ий нэг хувьд хүрэхгүй (0.87 хувь) хэмжээний хөрөнгө шаардлагатай болно.

Нийгмийн хамгааллын суурь түвшний нийт зардал 2014 онд хийсэн тооцооллын үр дүнгээс бараг ДНБ-ий нэг хувиар өндөр байгаа нь Засгийн газрын нийгмийн хамгааллын зарлага мөн ДНБ-ий 1.53 хувиар өсөхөөр байгаатай холбоотой.

**Зураг 3. Нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх хувь, одоогийн нийгмийн хамгааллын зардлыг нийгмийн хамгааллын суурь түвшний зардалтай харьцуулсан байдал (2016 оны төсөөллийг ашиглан тооцсон)**



Эх сурвалж: ОУХБ-ын тооцоо, 2016

Гэсэн ч эдгээр хувь хэмжээг Засгийн газар иргэн бүрт бэлэн мөнгө тарааж байсан 2010-2012 оны нийгмийн хамгааллын зардлын түвшинтэй харьцуулахад хавьгүй бага байгаа юм. Нийгмийн хамгааллын зардал 2011 онд хамгийн өндөр буюу ДНБ-ий 8.39 хувьтай тэнцэж байсан бол нийгмийн хамгааллын суурь түвшний 2016-2020 оны зардлын төсөөллөөс үзэхэд 2019 онд хамгийн өндөр түвшинд буюу ДНБ-ий 6.84 хувьд хүрэхээр байна. Бодлого тогтвортой өнөөгийнхөөс өөрчлөгдөхгүй байх нөхцөлд нийгмийн хамгааллын суурь түвшний зардал ямар байхыг Зураг 3-аас харж болно.

Түүнээс гадна Хүснэгт 2-т үзүүлсэнчлэн Монгол Улсын нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх хувь дэлхийн дундаж(8.8 хувь)-аас доогуур хэвээр байна. Гэхдээ энэ нь одоогоор Саб-Сахарын Африкийн орнуудын түвшнээс нэг их өндөргүй байгаа Ази, номхон далайн бүсийн дундаж (4.6 хувь)-аас дээгүүр байна. Үндэснийхээ хэмжээнд тодорхойлсон нийгмийн хамгааллын суурь түвшний энэхүү зардлын хэмжээгээр Монгол Улс Төв болон Зүүн Европын орнуудаас дунджаар 3 дахин доогуур түвшинд байна.

<sup>2</sup> Монгол Улсад төсвийн нийгмийн хамгааллын зарлага нь нийгмийн халамжийн зардал, төсвөөс нийгмийн даатгалын санд олгох дэмжлэг, Хүний хөгжил сангаас олгож буй нийгмийн тэтгэмж, тусламжаас бүрддэг.

**Хүснэгт 2. Төсвийн нийгмийн хамгааллын зардлын бүсийн дундаж (нийт хүн амын тоогоор жигнэсэн), баталгаа түс бүрээр, хамгийн сүүлийн боломжит оноор (ДНБ-д эзлэх хувь)**

| Бүс, улс                     | Нийгмийн хамгааллын нийт зардал | Төсвөөс санхүүждэг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал | Төсвөөс санхүүждэг ахмад настны нийгмийн хамгааллын зардал | Төсвөөс санхүүждэг хөдөлмөрийн идэвхтэй насны хүн амын нийгмийн хамгааллын зардал <sup>1</sup> | Нийгмийн халамжийн нийтлэг тэтгэмж, тусламж | Төсвөөс санхүүждэг хүүхдийн нийгмийн хамгааллын зардал |
|------------------------------|---------------------------------|---------------------------------------------------------------|------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------|--------------------------------------------------------|
| Африк                        | 4.3                             | 2.6                                                           | 1.3                                                        | 0.4                                                                                            | 0.2                                         | 0.2                                                    |
| Хойд Африк                   | 10.0                            | 3.2                                                           | 5.0                                                        | 1.1                                                                                            | 0.3                                         | 0.4                                                    |
| Саб-Сахарын Африк            | 4.3                             | 2.6                                                           | 1.1                                                        | 0.3                                                                                            | 0.2                                         | 0.1                                                    |
| Ази, номхон далайн бүс       | 4.6                             | 1.5                                                           | 2.0                                                        | 0.4                                                                                            | 0.4                                         | 0.2                                                    |
| Баруун Европ                 | 27.1                            | 7.9                                                           | 11.1                                                       | 5.0                                                                                            | 0.9                                         | 2.2                                                    |
| Төв болон Зүүн Европ         | 17.8                            | 4.4                                                           | 8.3                                                        | 3.0                                                                                            | 1.3                                         | 0.8                                                    |
| Латин Америк, Карибын орнууд | 13.9                            | 4.0                                                           | 4.6                                                        | 2.0                                                                                            | 2.6                                         | 0.7                                                    |
| Хойд Америк                  | 17.0                            | 8.5                                                           | 6.6                                                        | 2.8                                                                                            | 1.1                                         | 0.7                                                    |
| Ойрхи Дорнод                 | 11.0                            | 2.0                                                           | 3.3                                                        | 1.5                                                                                            | 3.4                                         | 0.8                                                    |
| Дэлхий                       | 8.8                             | 2.8                                                           | 3.3                                                        | 1.5                                                                                            | 0.7                                         | 0.4                                                    |

<sup>1</sup> Хөдөлмөрийн идэвхтэй насны хүмүүст зориулсан нийгмийн тэтгэмж, тусламж (нийгмийн халамжийн нийтлэг тэтгэмж, тусламжийг оруулаагүй).

Эх сурвалж: ОУХБ, Дэлхийн нийгмийн хамгааллын илтгэл 2014–15 (ОУХБ, 2015).

## Дүгнэлт

Монгол Улсад эдийн засгийн хямралын үед хүн бүрийн орлогын баталгааг хангаж, нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломжийг нь бүрдүүлэхэд ДНБ-ий 1.19 хувьтай тэнцэх зардал нэмж шаардагдана. Ингэснээр нийгмийн хамгааллын нийт зардал ДНБ-ий 5.79 хувьд хүрнэ. Өөрөөр хэлбэл, 2020 онд нийгмийн хамгааллын суурь түвшинг хангахад нэг сард нэг хүнд 47,980 төгрөг буюу **20 ам.доллар**<sup>3</sup> зарцуулах бол одоогийн нийгмийн хамгааллын зардал дээр нэмж шаардагдах нь сард нэг хүнд 4 ам.доллар болох юм.

Нийгмийн хамгааллын суурь түвшнийг хангаснаар одоо хэрэгжиж буй хөтөлбөрүүдээс гадна а)эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийг нь бүрдүүлэхийн тулд эмзэг бүлгийнхэн, малчдын шимтгэлийг нь хариуцах замаар эрүүл мэндийн даатгалд бүх нийтийг хамруулах; б)ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгож байгаагаас гадна бүх хүүхдэд олгож буй хүүхдийн мөнгийг хэвээр үргэлжлүүлж, хэмжээг нь индексжүүлдэг болох; в)малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засагт ажиллагчдын төлөх шимтгэлд дэмжлэг үзүүлэх замаар нийгмийн даатгал, түүний дотор тэтгэврийн даатгалд бүх нийтийг хамруулах; г)зорилтот бүлэгт, ялангуяа залуу малчид, эмзэг бүлгийнхэнд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үр дүнтэй хөтөлбөрүүдийг нэвтрүүлэх баталгаа бүрдэх юм.

<sup>3</sup> 2016 оны 12 сарын 10-ны өдрийн ханш: US\$1 = MNT2478.6